



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/407

Улаанбаатар хот

┌ Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,118,304.70 (долоон сая нэг зуун арван найман мянга гурван зуун дөрвөн төгрөг далан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг (Т.Сувдмаа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 773,540.00 (долоон зуун далан гурван мянга таван зуун дөч) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 20 нэр төрлийн 6,344,764.70 (зургаан сая гурван зуун дөчин дөрвөн мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг далан мөнгө) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 30,000 (гучин мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг (Т.Сувдмаа)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001105



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн А/№.7 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨАУ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	DVD тоглуулагч	18	ш	1	108,540.00	108,540.00	108,540.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	устгах	устгах
2	Даруулт хөгжим	13	ш	1	560,000.00	560,000.00	560,000.00	0.00	эвдэрхий	Актлах	5,000	10,000	10,000
3	Махны машин	13	ш	1	260,000.00	260,000.00	260,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	устгах	устгах
4	Махны машин	9	ш	1	150,000.00	150,000.00	150,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	устгах	устгах
5	Проектор	9	ш	1	699,000.00	699,000.00	699,000.00	0.00	эвдэрхий	Актлах	4,000	5,000	5,000
6	Хөгжим	9	ш	1	95,000.00	95,000.00	95,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	устгах	устгах
7	Хөргөгч	7	ш	1	318,000.00	318,000.00	318,000.00	0.00	эвдэрхий	Актлах	10,000	15,000	15,000
8	Компьютер notebook	9	ш	1	950,000.00	950,000.00	950,000.00	0.00	эвдэрхий	Актлах	5,000	5,000	5,000
9	Компьютер	11	ш	1	988,900.00	988,900.00	988,900.00	0.00	эвдэрхий	Актлах	12,000	12,500	12,500
10	Компьютер	15	ш	1	610,625.80	610,625.80	610,625.80	0.00	эвдэрхий	Актлах	12,000	12,500	12,500
11	Өнгөт принтер	7	ш	1	420,000.00	420,000.00	420,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	устгах	устгах
Тоног төхөөрөмжийн дүн						5,160,065.80	5,160,065.80	0.00			53,000	70,000	70,000
12	Өндөр шүүгээ	42	ш	3	26,954.10	80,862.30	80,862.30	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
13	Сандал	12	ш	3	46,125.00	138,375.00	138,375.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
14	Хүүхдийн ширээ	11	ш	1	89,000.00	89,000.00	89,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
15	Хүүхдийн ширээ	11	ш	5	30,000.00	150,000.00	150,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
16	Хүүхдийн ширээ	12	ш	24	45,500.00	1,092,000.00	1,092,000.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах	30,000	30,000
17	Бичгийн ширээ	42	ш	1	121,203.00	121,203.00	121,203.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
18	Гал тогоо шүүгээ	42	ш	2	10,854.00	21,708.00	21,708.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
19	сандал хивс	28	ш	5	466.67	2,333.35	2,333.35	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
20	Түшлэгтэй сандал	18	ш	2	25,326.00	50,652.00	50,652.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		
21	Эргэдэг сандал	19	ш	1	86,832.00	86,832.00	86,832.00	0.00	эвдэрхий	Актлах	устгах		

